



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 11/683

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Худалдан авах  
ажиллагааны албаны эргэлтийн  
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,693,000.0 /нэг сая зургаан зуун ерэн гурван мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба /Э.Буян-Өлзий/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба /Э.Буян-Өлзий/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 1<sup>д</sup> дугаар  
 сарын 27 өдрийн 2/63 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХК-ын хурлын шийдвэр
<b>Машин, тоног төхөөрөмж</b>										
1	Суурин компьютер	5	ш	1	1,524,000.00	1,524,000.00	1,524,000.00	-	Эх хавтан шатсан.	татах
2	Принтер	6	ш	1	169,000.00	169,000.00	169,000.00	-	Эвдэрсэн, ашиглах боломжгүй.	татах
<b>Машин, тоног төхөөрөмжийн дүн</b>				<b>2</b>		<b>1,693,000.00</b>	<b>1,693,000.00</b>	-		
<b>Нийт дүн</b>				<b>2</b>		<b>1,693,000.00</b>	<b>1,693,000.00</b>	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө										
Татан төвлөрүүлэх хөрөнгө					1,693,000.00					
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/										